

RCH 2.0 програмд үзмэрийн хувийг дугаарыг бичих талаар

Соёлын өвийн бүртгэлийн “RCH2.0” програмд үзмэрийг бүртгэхтэй холбогдуулан дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

2007-2008 оны улсын тооллогын үеэр зарим музейнүүд холбогдох дүрэм, журамд нийцүүлэн үзмэрүүдийнхээ хувийн дугаарыг шинэчлэн өөрчилжээ. Музейнүүдээс УНБМСанд ирүүлж байгаа бүртгэлээс үзэхэд програмын “хувийн дугаар” хэсэгт улсын тооллогын үеэр үзмэрт шинэчлэн өгсөн “шинэ хувийн дугаар” болон “хуучин хувийн дугаар” хоёрыг давхар бичих явдал гарч байна.

“Хувийн дугаар” гэсэн талбарт танай музейн үзмэрийн зөвхөн хүчин төгөлдөр хувийн дугаарыг бичнэ гэдгийг анхаарна уу.

Хэрэв улсын тооллогоор тухайн үзмэрт шинэ хувийн дугаар өгсөн бол “Хувийн дугаар” талбарт зөвхөн шинэ хувийн дугаарыг нь бичнэ. Хувийн дугаар өөрчлөгдөөгүй бол хуучин дугаарыг нь бичнэ.

Хэрэв “Хувийн дугаар” талбарт хуучин, шинэ хувийн дугаарыг давхар бичвэл програмаас хувийн дугаарын давхардлыг автоматаар шалгах боломжгүй болох юм.

Музейн сан хөмрөгийн улсын тооллогын үеэр албан ёсоор үзмэрийн хувийн дугаар өөрчлөгдсөн бол энэ тухай мэдээллийг “Товч түүх” талбарт дэлгэрэнгүй бичнэ. Бичихдээ хэдэн оны улсын тооллогоор, хэний тушаал шийдвэрээр, ямар шалтгааны улмаас хуучин хувийн дугаарыг яаж шинэчилсэн дугаар өгч өөрчилсөн зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ.

Жишээлбэл: Энэхүү хэт хутга нь 65.27 хувийн дугаар бүхий зэс хувинтай хувийн дугаар нь давхардсан байсан тул музейн сан хөмрөгийн 2007 оны улсын тооллогын үеэр музейн захирлын 2007 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тоот тушаалаар “65.27” гэсэн хувийн дугаарын давхардлыг засаж, “65.75” гэсэн шинэчилсэн дугаартай болгон өөрчилсөн г.м

“Товч түүх” талбарт дурсгалт зүйлийг хэн, хэрхэн бүтээсэн, уламжлан хадгалж ирсэн зэрэг түүнийг музейд орохоос өмнөх үеийн холбогдох түүхийг бичихээс гадна музейд орсноос хойш түүний бүртгэн баримтжуулахтай холбогдон гарсан өөрчлөлтийн талаарх мэдээллийг тушаал, шийдвэрийн хамтаар дэлгэрэнгүй бичнэ.